



“ГАН ЗАМ ДААТГАЛ” ХХК

2022

**“ГАН ЗАМ ДААТГАЛ” ХХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2023

Агуулга

Компанийн жилийн эцсийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт	3
Компанийн засаглал, ил тод байдал	3
Компанийн 2022 оны даатгалын үйл ажиллагаа	3-5
Даатгалын хураамжийн орлого	4
Даатгалын нөхөн төлбөр	5
Компанийн даатгал, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, ашиг	6
Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Компанийн хөрөнгө, санхүү, төлбөрийн чадвар	7
Санхүүгийн байдлын тайлан	7-8
Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт	9
Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын гүйцэтгэлийн шалгуур	9-10
Оролцогч талуудын хамтын ажиллагаа	10

“Ган зам даатгал” ХХК-ийн 2022 оны жилийн
үйл ажиллагааны тайлан

Компанийн жилийн эцсийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт

Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гарган, Санхүүгийн зохицуулах хороо/СЗХ/, Сангийн яам, Татварын ерөнхий газарт цахимаар илгээсэн бөгөөд мөн тайлан тэнцлээ даатгалын нөөц сангийн актуар тайлан, эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлангийн хамт СЗХ-нд бичгээр хүргүүлээ.

Компанийн 2022 оны даатгал, санхүүгийн үйл ажиллагааны тайланд Хувьцаа эзэмшигчдийн Хурлаас томилогдсон, Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компаниудад аудит хийх эрх авсан “Бэст фортуна аудит” ХХК аудит хийж, “Ган зам даатгал” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн бодитой илэрхийлэгдсэн байна” гэсэн дүгнэлт гаргасан.

Компанийн засаглал, ил тод байдал

Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн хураангуй болон хараат бус аудиторын дүгнэлтийг өдөр тутмын “Зууны мэдээ” сонины 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн № 33 (7018) дугаарт нийтлүүлэн “Даатгалын тухай хууль”-д заасны дагуу олон нийтэд мэдээлсэн.

Компанийн засаглалыг боловсронгуй болгох, санхүүгийн зах зээлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниудыг хамруулж, үйл ажиллагаандаа мөрдөхийг үүрэгжүүлсэнтэй холбогдуулан дээрх тогтоолын дагуу “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган холбогдох бодлогын баримт бичиг, журам, зааврыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан батлуулсан бөгөөд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 6, 10 дугаар саруудад 2 удаа заасан хугацаанд гаргаж, СЗХ-нд цахимаар илгээж, тайлагнасан. Мөн компанийн засаглалын холбогдох баримт бичгүүдийг компанийн цахим хуудсанд байршуулсан.

Компанийн 2022 оны даатгалын үйл ажиллагаа

Компани СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу сайн дурын гэнэтийн ослын даатгал, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал, хөдөлгөөнтэй холбоотой болон аюултай бүсэд ажиллагсдын гэнэтийн ослын


даатгал, зорчин явагчдын гэнэтийн ослын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, мэргэжлийн хариуцлага, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалуудыг хийж, даатгалын тохиолдол гарсан тухай бүр хохирлын үнэлгээ, бусад холбогдох бичиг баримтуудыг үндэслэн даатгуулагчдад зохих журмын дагуу даатгалын нөхөн төлбөрийг цаг хугацаанд нь шуурхай олгож ажилласан.

2022 онд даатгалын 685 гэрээ байгуулж, 10 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулан даатгалын хураамж 807.8 сая төгрөг болж, өмнөх оныхоос 29.0 хувь буюу 181.8 сая төгрөгөөр өссөн.

Хураамжийн орлого /даатгалын хэлбэрээр/:

Даатгалын хэлбэр	2021	2022	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт Дүн	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал /ГОЭД/	462.5	643.4	180.9	39.1
Тээврийн хэрэгслийн даатгал /ТХД/	106.9	114.4	7.5	7.0
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /ЖХАЖД/	49.6	49.9	0.3	0.6
Мэргэжлийн хариуцлагын даатгал /МХД/	7.0	0.1	(6.9)	(98.6)
Нийт хураамжийн орлого	626.0	807.8	181.8	29.0

2022 оны даатгалын хураамжийн орлогын бүтэц /хувиар/




Даатгалын хохирлын нөхөн төлбөр олгох ажлыг шуурхай бөгөөд даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл, чирэгдэлгүй зохион байгуулж, 2022 онд 1973 даатгуулагчийн даатгалын хохирлын холбогдох баримт, материалыг хүлээн авч, шалган тооцож, 400.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон.

Нөхөн төлбөр /даатгалын хэлбэрээр/:

Даатгалын хэлбэр	2021	2022	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал /ГОЭД/	348.8	291.0	(57.8)	16.6
Тээврийн хэрэгслийн даатгал /ТХД/	36.9	81.9	45.0	122.0
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /ЖХАЖД/	25.2	27.4	2.2	8.7
Нийт хураамжийн орлого	410.9	400.3	(10.6)	2.6

2022 оны даатгалын нөхөн төлбөрийн бүтэц /хувиар/



Тайлант хугацаанд даатгуулагчдын зүгээс даатгалын нөхөн төлбөртэй холбоотой ямар нэгэн гомдол, маргаантай асуудал гараагүй, компани даатгуулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллалаа.

Компанийн даатгал, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, ашиг

2022 онд компанийн нийт ашиг 857.1 сая төгрөг болж, өмнөх оныхоос 5.7 хувь буюу буюу 46.1 сая төгрөгөөр, цэвэр ашиг 770.2 сая төгрөг болж, өмнөх оныхоос 5.2 хувь буюу 38.2 сая төгрөгөөр өссөн.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31 өдөр

"ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК

№	Үзүүлэлт	2022 оны 01-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
A	B	1	2
1	Даатгалын үйл ажиллагаа		
2	Даатгалын хураамжийн нийт орлого	626,060,361.00	807,763,455.00
3	Даатгалын хураамжийн буцаалт (-)	129,357.00	176,988.00
4	Давхар даатгалын хураамжийн зардал (-)		
5	Даатгалын хураамжийн цэвэр орлого (мөр5=мөр(2+3+4))	625,931,004.00	807,586,467.00
6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт (+,-)	9,152,083.23	6,186,510.85
7	Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт (+,-)		
8	Орлогод тооцсон хураамж (5-6-7)	616,778,920.77	801,399,956.15
9	Нийт нөхөн төлбөрийн зардал	410,896,229.00	400,299,909.00
10	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр (+)		
11	Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр (+)		
12	Нөхөн төлбөрийн цэвэр зардал (9-10-11)	410,896,229.00	400,299,909.00
13	Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(216,028,008.49)	(226,326,758.83)
14	Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт (+,-)		
15	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт (+,-)		
16	Зардалд тооцсон нөхөн төлбөр (12+13+14+15)	194,868,220.51	173,973,150.17
17	Даатгалын гэрээний зардал (-)		
18	Давхар даатгалын шимтгэлийн орлого (+)		
19	Хөрөнгө оруулалтын олз, гарз (+,-)	800,965,622.87	655,995,342.40
20	Даатгалын үйл ажиллагааны ашиг(алдагдал)(8-16+17+18+19)	1,222,876,323.13	1,283,422,148.38
21	Түрээсийн орлого (+)		
22	Хүү, Эрхийн шимтгэлийн орлого (+) / Харилцахын хүү/	374,999.10	
23	Бусад орлого (+)	175,614.42	249,098.64
24	Ерөнхий ба удирдлагын зардал (-)	(411,794,880.99)	(426,632,210.51)
25	Борлуулалт, маркетингийн зардал (-)		
26	Санхүүгийн зардал (-)	(650,000.00)	
27	Бусад зардал (-)		
28	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) (+,-)	(57.70)	48,420.66
29	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) (+,-)		
30	Бусад ашиг (алдагдал) (21+...+29)	(411,894,325.17)	(426,334,691.21)
31	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) (20+30)	810,981,997.96	857,087,457.17
32	Орлогын албан татварын зардал	78,985,432.04	86,901,888.53
33	Татварын дараах ашиг (алдагдал) (31-32)	731,996,565.92	770,185,568.64
34	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) (+,-)		
35	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (33+34)	731,996,565.92	770,185,568.64
36	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
37	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
38	Бусад		
39	Орлогын нийт дүн (35+36+37+38)	731,996,565.92	770,185,568.64
40	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Захирал _____ / В.Отгондэмбэрэл /

Ня-бо _____ / И.Батчимэг /

Компанийн хөрөнгө, санхүү, төлбөрийн чадвар

Даатгалын нөхөн төлбөрийн нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооноос мөрдүүлж буй журмаар тооцон 2022 онд 22.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба 2022 оны жилийн эцсийн байдлаар нөхөн төлбөрийн нөөц сан 643.1 сая төгрөг, компанийн нийт актив 6835.6 сая төгрөг болсон.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31 өдөр

"ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	В	Үлдэгдэл	
			2022 оны 01-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
А	Б	В	1	2
1	ХӨРӨНГӨ	1		
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2		
1.1.1	Бэлэн мөнгө	3		
1.1.2	Харилцах	4	8,958,542.39	32,652,643.40
1.1.3	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	5	24,597,955.46	1,723,468,563.97
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүний авлага	6		
1.1.5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	7	33,556,497.85	1,756,121,207.37
1.2	Даатгалын авлага	8		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага /цэвэр дүнгээр/	9	255,426,479.00	336,002,252.00
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага /цэвэр дүнгээр/	10		
1.2.3	Давхар даатгалаас авах авлага /цэвэр дүнгээр/	11		
1.2.4	Даатгалын авлагын дүн	12	255,426,479.00	336,002,252.00
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө	13		
1.3.1	Бусад авлага /цэвэр дүнгээр/	14	57,750.00	57,750.00
1.3.2	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	15	57,750.00	57,750.00
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө	16		
1.4.1	НДШ авлага, бусад татварын авлага	17		
1.4.2	ААНОАТатварын авлага	18		
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	19		
1.4.4	Бараа материал	20	8,479,370.00	8,894,365.00
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	21		4,000,000.00
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	22		
1.4.7	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	23	8,479,370.00	12,894,365.00
1.5	Хөрөнгө оруулалт	24		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат	25	6,017,882,153.40	4,011,451,797.22
1.5.2	Үнэт цаас /цэвэр/	26	671,823,972.60	670,676,342.46
1.5.3	Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	27		
1.5.4	Үнэт металл, Дериватив	28		
1.5.5	Хөрөнгө оруулалтын дүн	29	6,689,706,126.00	4,682,128,139.68
1.6	Даатгалын хөрөнгө	30		
1.6.1	ДД-ын хойшлогдсон хураамж	31		
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	32		
1.6.3	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	33		
1.6.4	Даатгалын хөрөнгийн дүн	34		
1.7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	35	67,564,258.89	48,371,717.45
1.8	Биет бус хөрөнгө /Цэвэр/	36	756,164.38	
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	37		

1.10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38	7,055,546,646.12	6,835,575,431.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	39		
2.1	ӨР ТӨЛБӨР	40		
2.1.1	Даатгалын өглөг	41		
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	42		
2.1.1.2	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	43		
2.1.1.3	ДД өгөх өглөг	44		
2.1.1.4	Даатгалын өглөгийн дүн	45		
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр	46		
2.1.2.1	Зээлийн өглөг, хүү	47		
2.1.2.2	Өрийн бичиг, хүү	48		
2.1.2.3	Санхүүгийн түрээсийн өр төлбөр	49		
2.1.2.4	Ногдол ашгийн өглөг	50		
2.1.2.5	Деривативын өр төлбөр	51		
2.1.2.6	Бусад өр төлбөр	52	57,882.00	54,444.00
2.1.2.7	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	53	57,882.00	54,444.00
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр	54		
2.1.3.1	Цалингийн өглөг	55		
2.1.3.2	НДШ-ийн өглөг	56		
2.1.3.3	ААНОАТатварын өглөг	57		9,581,608.73
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг	58		
2.1.3.5	Урьдчилж орсон орлого	59		
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр	60		
2.1.3.7	Хуулийн байууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр	61		
2.1.3.8	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион	62		
2.1.3.9	Тэтгэврийн сангийн өр төлбөр	63		
2.1.3.10	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	64		
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр	65		
2.1.3.12	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	66	-	9,581,608.73
2.1.4	Хойрдогч өглөг	67		
2.1.5	Давуу эрхийн хувьцаа (хөрвөхгүй)	68		
2.1.6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	69	306,255,987.91	312,442,498.76
2.1.7	Нөхөн төлбөрийн нөөц сан	70		
2.1.7.1	Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	71	189,533,009.16	211,510,550.33
2.1.7.2	Мэдсэн боловч төлөөгүй ХНС	72	14,342,985.00	14,342,985.00
2.1.7.3	Учирч болзошгүй ХНС	73	147,556,317.14	147,556,317.14
2.1.7.4		74		
2.1.7.5	Тусгай нөөц сан	75	518,006,854.28	269,702,554.28
2.1.7.6	Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	76	869,439,165.58	643,112,406.75
2.1.8	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	77	1,175,753,035.49	965,190,958.24
2.2	ЭЗДИЙН ӨМЧ	78		
2.2.1	Эзэмшигчдийн өмч	79	5,000,000,000.00	5,000,000,000.00
2.2.2	Халаасны хувьцаа	80		
2.2.3	Нэмж төлөгдсөн капитал	81		
2.2.4	Тогтвортой байдлын нөөц сан	82		
2.2.5	Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	83	55,274,363.00	55,274,363.00
2.2.6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	84		
2.2.7	Эздийн өмчийн бусад хэсэг	85	92,522,681.71	44,924,541.62
2.2.8	Хуримтлагдсан ашиг, алдагдал	86	731,996,565.92	770,185,568.64
2.2.9	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	87	5,879,793,610.63	5,870,384,473.26
2.3	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	88	7,055,546,646.12	6,835,575,431.50

Захирал

/В.Отгондэмбэрэл/

Ня-бо




/И.Батчимэг/

БҮСТ ФОРТЭМА
АУДИТ НАХ

02 сар
07 дөр

Компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт буюу төлбөрийн чадварын зохистой харьцаа 2022 онд 114.08 хувь болж, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-д 110 хувь буюу түүнээс дээш байхаар заасан шаардлагыг 4.08 нэгжээр илүү хангасан.

Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт
/хувиар/



Компани 2022 онд нийгмийн даатгалын шимтгэлээр 89.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд, хувь хүний орлогын албан татвараар 60.1 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар 86.9 сая төгрөг, нийт 236.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулж, нийгмийн даатгалын байгууллага, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан.

Компанийн гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын гүйцэтгэлийн шалгуур

Цалин: Хөдөлмөрийн гэрээний дагуу сарын үндсэн болон нэмэгдэл цалинг тухайн сард ажиллавал зохих өдрөөс ажилласан өдрөөр;

Сар, улирлын урамшуулал: Сар, улирлаар урамшуулал 0 /олгохгүй/;

Үр дүнгийн урамшуулал: Компанийн даатгал, санхүүгийн үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн үр дүнгээр “Үр дүнгийн урамшуулал” олгох бөгөөд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

ТУЗ-ийн баталсан нийт болон цэвэр ашгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувь буюу түүнээс дээш биелсэн;

Даатгалын үйл ажиллагааны зардал төлөвлөснөөс хэтрээгүй байх;

ТУЗ-ийн баталсан ногдол ашгийн төлөвлөгөөг биелүүлсэн байх.

Дээрх шалгуурыг харгалзан ТУЗ-ийн Цалин, урамшууллын хорооны оруулснаар ТУЗ-ийн хурлаар гүйцэтгэх захирлын үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг хэлэлцэн батална.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа

Тайлант хугацаанд компани оролцогч талууд болох даатгуулагч, үйлчлүүлэгч иргэд, харилцагч байгууллагуудынхаа эрх ашгийг ямагт хүндэтгэн харилцан ашигтай, үр дүнтэй хамтын ажиллагааг явуулахыг гол стратеги зорилт болгон ажилласан. Ялангуяа даатгуулагчдынхаа эрх ашгийг дээдэлж, даатгалын үйл ажиллагааны нэг чухал хэсэг болох даатгалын хохирлын нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай тогтоож олгох ажлыг даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл, чирэгдэлгүй зохион байгуулахад чиглүүлж ажилласнаар тайлант хугацаанд даатгуулагчдын зүгээс даатгалын нөхөн төлбөртэй холбоотой ямар нэгэн гомдол, маргаантай асуудал гараагүй.

Даатгуулагч болон бусад харилцагчидтай хийсэн гэрээний сахилга бат, гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлж, тэдний өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай, чанартай, бүрэн биелүүлж, итгэл найдварыг хүлээж ирлээ.

Бид харилцааны найдвартай, соёлтой бөгөөд хүндэтгэлтэй, хөнгөн шуурхай үйлчилгээг оролцогч-харилцагч бүрт үзүүлснээр хамтын ажиллагааны үнэ цэнийг өсгөж, дунд, урт хугацааны итгэлтэй түншлэлийг бий болгож, өргөжүүлэхийн төлөө ажиллаж, мэдээлэл, түүний ил тод байдалд ач холбогдол өгч, мэдээлэл өгөх уулзалт, яриа зохион байгуулан мөн цахим хуудсаа үр дүнтэй ажиллуулсан.

Цаашид оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгийг судалгааны үндсэн дээр боловсруулж, компанийн ТУЗ-ийн ээлжит хурлаар батлуулах, мөн компанийн ажиллагсадын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, тэдний мэргэжил дээшлүүлэх болон нийгмийн асуудлыг зохицуулах журмыг компанийн онцлогтой уялдуулан боловсруулж, гаргах болно.

“Ган зам даатгал” ХХК